



**ХЭНТИЙ АЙМАГ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 01

Чингис хот

Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн тухай

Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1, 39.1.1, Улсын Их Хурлын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, уг албан тушаалд нэр дэвшигчийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын 16, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.3, 2.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн, Хэрлэн сумын иргэн Б.Түмэнжаргалын өргөдлийг хянан шалгасан дүгнэлтийг хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/63 дугаартай “Б.Түмэнжаргалд сахилгын шийтгэл ногдуулах тухай” тушаал нь хууль зүйн үндэслэлгүй гэж үзсүгэй.

2. Боловсрол, соёл, урлагийн газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн Б/63 дугаартай “Б.Түмэнжаргалд сахилгын шийтгэл ногдуулах тухай” тушаалыг хүчингүй болгохыг Боловсрол, соёл, урлагийн газрын дарга /С.Мөнхцэцэг/-д даалгасугай.

3. Өргөдлийн хариуг албан бичгээр хүргүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Болормаа/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

